Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А-1/2515 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

**(2025 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр)**

**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар**

2025.12.17

| Зорилго | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | АХ: № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2023) | Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) | | | ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ (сая төгрөг) 2025 он | | | Хэрэгжилтийн үнэлгээ (хувиар) | Хэрэгжилт хангалтгүй бол шалтгаан тайлбарыг дэлгэрэнгүй бичих | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилтот түвшин | Төсөв (сая.төгрөг) | Санхүүжилтийн эх үүсвэр | ХЭРЭГЖИЛТ (Хүрсэн түвшин, Үр дүн) | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг) | Зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр | | | Үндсэн | Хамтран |
| **ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| **3.1. Эдийн засгийн эрх чөлөө** | | | | | | | | | | | | | | | | |
| **3.1.2.Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа** | 3.1.2.4.Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ. | 485 | "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2025-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл" болон тухайн жилд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг баталж, хэрэгжүүлэх | 2025-2028 | Арга хэмжээний хэрэгжилт, хувь | - | 10 | 350.00 | Улсын болон орон нутгийн төсөв | **ТӨБЗГ - ТӨУЗХ**: "Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаат 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, ТӨБЗГ-ын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А-1/1307 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу холбогдох Яамдын Сайд нарын саналыг авч тусган УИХ-ын тогтоолын төслийг дахин боловсруулж, ТӨБЗГ-ын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А-1/1580 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хуралдаанаар тус төслийг хэлэлцээд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган, "Шинэ итгэл-Эрс шинэтгэл" "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д нийцүүлэн дахин боловсруулахаар 30.4 дүгээр тэмдэглэлд тусган шийдвэрлэсэн. Засгийн газрын тэмдэглэлийг хэрэгжүүлэх хүрээнд "Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаат 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг дахин боловсруулж, 18 хуулийн этгээдэд IPO хийх, 8 этгээдийн төрийн мэдлийн хувьцааг худалдах, 7 хуулийн этгээдэд бүтцийн өөрчлөлт хийх саналыг тусган ЗГХЭГ-т хүргүүлснийг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Засгийн газраас УИХ-д уг тогтоолын төслийг өргөн барихаар тогтсон.<br>Уг төслийг боловсруулах ажлын хүрээнд Засгийн газрын гишүүд, "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрчист Монгол" ХХК, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Нээлттэй Нийгэм Форум, түүний дэргэдэх Эдийн засгийн зөвлөлийн санал, зөвлөмж, дүгнэлтийг авч, судлан тусгах арга хэмжээ авснаас гадна Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны https://pcsp.gov.mn/?p=7964 цахим хуудсанд нээлттэй байршуулж, иргэд, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулсан. | 0 | - | 90 | | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | Сангийн яам |
| **ДӨРӨВ.ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | |
| **4.1. Хүний эрх, эрх чөлөө** | | | | | | | | | | | | | | | | |

| Зорилго | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | АХ: № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2023) | Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) | | | ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ (сая төгрөг) | | | Хэрэг-жилтийн үнэлгээ (хувиар) | Хэрэгжилт хангалтгүй бол шалтгаан тайлбарыг дэлгэрэнгүй бичих | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 он | | | | | | | | | |
| | | | | | | | Зорил-тот түвшин | Төсөв (сая.төг-рөг) | Санхүү-жилтийн эх үүсвэр | ХЭРЭГЖИЛТ (Хүрсэн түвшин, Үр дүн) | Зарцуул-сан хөрөнгийн хэмжээ (сая.төг-рөг) | Зарцуул-сан хөрөн-гийн эх үүсвэр | | | Үндсэн | Хамтран |
| **4.1.4.Ил тод байдал ба хяналт** | 4.1.4.2.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилнэ. | 1063 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулахад чиглэсэн анхдагч хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 2025 | Арга хэмжээний хэрэгжилт, хувь | - | 100 | 200.00 | Улсын болон орон нутгийн төсөв | **ТӨБЗГ - ХЭЗХ.** 1. Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн хууль (Шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 07 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар тус тус хэлэлцэн дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. Тус Байнгын хорооны дэргэд Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.<br>2. Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэн дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн.<br>УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, тус хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хамтран Европын сэргээн босголт, хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй хэрэгжүүлж буй "Төрийн өмчийн менежментийн шинэчлэл" төслийн хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр "Төрийн өмчит компанийн эрх зүйн шинэчлэлт, төрийн өмчлөлийн бодлогыг боловсронгуй болгох нь" олон улсын онол, практикийн бага хурлыг Төрийн ордонд зохион байгуулж, төрийн өмчит компанийн шинэчлэлтэй холбоотой илтгэл, олон улсын туршлага, танилцуулгыг сонсож, уг хуулийн төсөл, үзэл баримтлалыг хэлэлцүүлсэн байна. Дээрх хоёр хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхэд бэлтгэх ажлын хэсэг дээрх Байнгын хорооны дэргэд ажиллаж байна. | 0 | - | 100 | | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| | | 1064 | Төрийн болон орон нутгийн өмчийн асуудал хариуцсан байгууллагын чадавхыг бэхжүүлэх | 2025-2028 | Сургалт, арга хэмжээ, өссөн дүнгээр | 20 | 30 | 80.00 | Улсын болон орон нутгийн төсөв | **ТӨБЗГ - БҮХ ХЭЛТЭС.** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2025 онд өөрийн байгууллага болон нийслэл, аймгуудын орон нутгийн өмчийн асуудал хариуцсан байгууллагын албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчийн удирдлага, бүртгэл, цахим систем хариуцсан албан хаагчдыг чадавхижуулах сургалт, арга зүйн арга хэмжээг нийт дүнгээр 74 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 7149 байгууллагын 25,607 албан хаагчийг хамруулсан байна. | 110.70 | Улсын төсөв-(Гүйцэт-гэлээр: ӨЭГ, Бусийн сургалт, систем | 100 | | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар |

| Зорилго | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | АХ: № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2023) | Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) | | | ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ (сая төгрөг) | | | Хэрэг-жилтийн үнэлгээ (хувиар) | Хэрэгжилт хангалтгүй бол шалтгаан тайлбарыг дэлгэрэнгүй бичих | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 он | | | | | | | | | |
| | | | | | | | Зорил-тот түвшин | Төсөв (сая.төг-рөг) | Санхүү-жилтийн эх үүсвэр | ХЭРЭГЖИЛТ (Хүрсэн түвшин, Үр дүн) | Зарцуул-сан хөрөнгийн хэмжээ (сая.төг-рөг) | Зарцуул-сан хөрөн-гийн эх үүсвэр | | | Үндсэн | Хамтран |
| | | | | | Сургалтад хамрагдсан хүний тоо | 20 | 1,500 | | | Өмчийн харилцааны салбарт тулгамдаж байгаа болон анхаарах асуудлыг шийдвэрлэх, байгууллага, албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээний хамрагдалт:<br>-Орон нутгийн өмчийн хяналт шалгалтын ажлын чадавх сайжруулах сургалт, 1 удаа, 21 аймгийн ОНӨГ-ын 65 албан хаагч, 2025.01.20-22;<br>-Бүсийн уулзалт зөвлөгөөн, нийслэл, 1 удаа, 21 аймгийн орон нутгийн өмчийн байгууллагын 204 албан хаагч, 2025,06 сард;<br>-Хууль, эрх зүйн мэдлэг, ойлголт дээшлүүлэх сургалт, 4 удаа, 23 байгууллагын 298 албан хаагч;<br>-Компанийн засаглалын чиглэлээр хийсэн сургалт, 1 удаа, 5 аймгийн ОНӨГ-ын 260 албан хаагч, 2025.06 сард;<br>-Нийтийн өмчийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн хэлэлцүүлэг, 1 удаа, нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн байгууллагын удирдлага, албан хаагч, төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын удирдлага, нийт 36 байгууллагын 80 албан хаагч, 2025.05.05;<br>-Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын нэгдсэн сургалт цугларалт, 11 удаа (7 нь цахимаар), 1200 албан хаагч (давхардсан тоо);<br>-Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем нэвтрүүлэх болон орон нутагт байрлах төрийн өмчит байгууллагын өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэх ажлын хүрээнд хийсэн сургалт, 35 удаа (10 нь цахимаар), нийслэл, 21 аймгийн төрийн болон орон нутгийн өмчит 7000 орчим хуулийн этгээдийн 22,000 албан хаагч;<br>-Төсвийн ерөнхийлөн захирагч нараас зохион байгуулсан санхүүгийн ажилтны нэгдсэн цугларалт сургалт, төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын асуудлаар, 20 гаруй удаа, 1500 албан хаагч. | | Т.М: Нийт 49.2 сая төгрөг); Азийн хөгжлийн банкны санхүү-жилтээр 61.5 сая. Төгрөг. | | | | |

| Зорилго | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | АХ: № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2023) | Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) 2025 он: Зорил-тот түвшин | Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) 2025 он: Төсөв (сая.төг-рөг) | Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) 2025 он: Санхүү-жилтийн эх үүсвэр | ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ (сая төгрөг) 2025 он: ХЭРЭГЖИЛТ (Хүрсэн түвшин, Үр дүн) | ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ (сая төгрөг) 2025 он: Зарцуул-сан хөрөнгийн хэмжээ (сая.төг-рөг) | ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ (сая төгрөг) 2025 он: Зарцуул-сан хөрөн-гийн эх үүсвэр | Хэрэг-жилтийн үнэлгээ (хувиар) | Хэрэгжилт хангалтгүй бол шалтгаан тайлбарыг дэлгэрэнгүй бичих | Хэрэгжүүлэх байгууллага: Үндсэн | Хэрэгжүүлэх байгууллага: Хамтран |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1065 | Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хөгжүүлэх (Мэдээллийн сангийн программ хангамж, дэд бүтэц) | 2025-2028 | Систем хөгжүүлэлт, хувь | 10 | 60 | 300.00 | Улсын болон орон нутгийн төсөв | **ТӨБЗГ - ТӨБАХ.** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдан хэрэгжиж байгаа, нийт 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем, тоног төхөөрөмж" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр "Аствишн" ХХК ажиллав. ТӨБЗГ нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд орон нутгийн өмчийн харилцаанд өмчийн мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгох чиглэлээр мэргэжил, арга зүйгээр хангах, уг системийг төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбох, сервер тоног төхөөрөмж худалдан авч, нэгдсэн цахим системийг бий болгох ажлыг үе шаттай зохион байгуулж, 2025 оны 08 дугаар сараас улсын хэмжээний байгууллага, иргэд, олон нийтэд системийн ашиглалтыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд 2025 оны 6, 7 дугаар сард Орхон аймагт системийн урьдчилсан нэвтрүүлэлт, туршилт, тохируулгын ажлыг гүйцэтгэж, Орхон, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын нийт 20 гаруй албан хаагч, Орхон аймгийн төрийн болон орон нутгийн өмчит 16 байгууллагын 90 гаруй албан хаагч, нийт 110 албан хаагчийг хамруулсан арга зүйн сургалт зохион байгуулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2025.08.25-ны өдөр тус системийн хэрэглэгчдэд арга зүйг түгээж, системийг орон нутагт ажиллуулах эхний боловсон хүчин-сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг зохион байгуулж, нийслэл, орон нутгийн өмчийн харилцааны асуудал хариуцсан байгууллагын 150 гаруй мэргэжилтнүүдийг хамруулав. Мөн ТӨБЗГ болон "Аствишн" ХХК-ийн мэргэжилтнүүдээс бүрдсэн баг 10 дугаар сард нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төрийн болон орон нутгийн өмчит нийт 7000 гаруй байгууллагын 20,000 гаруй хэрэглэгч-албан хаагчдад нэгдсэн цахим системийг танилцуулах сургалт хийж, аргазүйгээр хангасан. | 27.60 | Улсын төсөв. Гүйцэт-гэлээр: Цахим систе-мийн сургалт-(нийслэл, 21 аймагт) | 100 | | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар |
| | | | | | | | | | | Төрийн болон болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн цахим системийн бүрдүүлэлт, хөгжүүлэлт, ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах асуудлыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд тус хуралдааны тэмдэглэлээр өгсөн 2026 оны 01 сарын 01 өдрөөс эхлэн төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд цахим системийг бүрэн ашиглах үүрэг даалгаврыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар бэлтгэж байна. Цахим системийг ажлын даалгаврын дагуу бүрэн бий болгож, ашиглалтад нэвтрүүлсэн бөгөөд программын нийт хөгжүүлэлтийн 60 хувийг 2025 онд гүйцэтгэж, оны зорилтот түвшинг бүрэн хангасан.<br>Шинээр бий болж байгаа цахим системд 2025 онд нэмэлт хөгжүүлэлт хийх ажилд батлагдсан 259.9 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээс Орхон аймагт хийсэн урьдчилсан нэвтрүүлэлт, туршилт тохируулгын ажилд 27.6 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэгч компанийн ажил удаашралтай холбоотойгоор хөгжүүлэлтийн ажилд шаардлагатай 232.3 сая төгрөгийг Сангийн яамнаас улсын төсөвт буцаан татсан болно (Анх 300.0 сая төгрөгийг төлөвлөж, 259.9 сая төгрөг батлагдан хуваарилагдсан байсан). | | | | | | |

НИЙТ 4 АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ ТАЙЛАГНАВ.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

| Зорилго | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | АХ: № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2023) | Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) | | | ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ (сая төгрөг) | | | Хэрэг-жилтийн үнэлгээ (хувиар) | Хэрэгжилт хангалтгүй бол шалтгаан тайлбарыг дэлгэрэнгүй бичих | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 он | | | | | | | | | |
| | | | | | | | Зорил-тот түвшин | Төсөв (сая.төг-рөг) | Санхүү-жилтийн эх үүсвэр | ХЭРЭГЖИЛТ (Хүрсэн түвшин, Үр дүн) | Зарцуул-сан хөрөнгийн хэмжээ (сая.төг-рөг) | Зарцуул-сан хөрөн-гийн эх үүсвэр | | | Үндсэн | Хамтран |

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ

ATA11111 6098169 9023126816